



ШИВЭЭ ОВОО ХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн Аудитын Газрын
дарга, тэргүүлэх аудитор
Ц.НАРАНЧИМЭГ
Утас: 263533
Цахим хаяг: www.audit.mn

Аудитын менежер:
Я.САМБУУНЯМ
Утас: 261885

Аудитор: НЯМДАВАА

Есөнхангай Аудит ХХК
Захирал Т.ОЮУНТУЯА
Утас: 99048991
Цахим хаяг: oyuntuya@cpa.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Материаллаг байдлын түвшин
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

“Төрийн аудитын тухай хууль” -ийн 15.1.2 –т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 болон 18.5 дугаарт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, “Төсвийн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дугаарт заасан цаглабараар Шивээ овоо ХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд хийх аудитын гэрээт ажлыг “Есөнхангай Аудит” ХХК гүйцэтгэж, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар хяналт тавина.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шивээ овоо ХК -ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Компанийн удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Шивээ овоо ХК-ийн 2016 оны 09 дүгээр сарын 30-наарх санхүүгийн тайланд завсрын аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 21-ний хооронд хийж гүйцэтгэсэн.

Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахимаар 2017 оны 02 дугаар сарын 20-нд, хэвлэмэл тайланг, холбогдох баримт бичгүүдийн хамт 2017 оны 03 дугаар сарын 6-нд Есөнхангай Аудит ХХК-д ирүүлсэн. Аудитын талбар дээрх ажлыг 2017 оны 03 дугаар сарын 06-наас 2017 оны 03 дугаар сарын 13–ны хооронд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн асуудлын бүртгэлийг 2017 оны 03 дугаар сарын 10-нд хүргүүлсэн ба залруулагдсан санхүүгийн тайланг Шивээ Овоо ХК нь 2017 оны 03 дугаар сарын 16-нд ирүүллээ. Аудитын тайланг 2016 оны 3 дугаар сарын 20-нд Шивээ Овоо ХК-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Шивээ овоо ХК нь Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль, "Компанийн тухай" хууль, "Ашигт малтмалын тухай" хууль, "Эрчим хүчний тухай" хууль, "Байгаль орчныг хамгаалах тухай" хууль, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журмуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Шивээ овоо ХК -ийн эрхэм зорилго нь байгаль орчинд ээлтэй, аюулгүй үйлдвэрлэл, өндөр бүтээмж бүхий уул уурхайн салбарын жишиг компани байна.

1990 онд Эрчим хүч, уул уурхайн Үйлдвэр, геологийн яам Налайх дахь Уурхайн барилга трестийн харъяанд Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг байгуулах шийдвэр гаргажээ.

1986-1988 онуудад Улсын төсвийн хөрөнгөөр Шивээ-Овоогийн нүүрсний ордод урьдчилсан болон нарийвчилсан хайгуул хийж 1989 оны 12-р сарын 22-ны өдрийн Улсын нөөцийн комиссын 33-р тогтоолоор ордын геологийн нөөцийг нь тогтоосон байдаг.

Шивээ-Овоогийн нүүрсний орд нь нийт 29500.0 га талбайг хамардаг бөгөөд нийт 2708.7 сая тн нүүрсний нөөцтэй, 3 үндсэн хэсгээс бүрдэж байна. Шивээ-Овоогийн ордын нүүрс нь Б-2 бүлгийн хүрэн нүүрсний ангилалд хамаарагдана. Орд нь нүүрсний нийт 8 давхаргатай бөгөөд одоогийн байдлаар I ба II давхаргаас олборлолт явагдаж байна. Нүүрсний I давхаргын зузаан 10.0 м, II давхаргын зузаан нь 7.0 м, нийт 17.0 м бөгөөд давхарга хоорондын үндсэн завсрын хөрсний зузаан 6.0 м-т хүрдэг боловч давхаргууд нь дотроо 0.2-4.0 м-ийн зузаан хөрсний үеүдтэй.

1990 онд ЭХУУ-ийн Зураг төслийн институт Шивээ-Овоогийн ордыг түшиглэн жилд 500.0 мян.тн нүүрс олборлох уурхайн зураг төслийг боловсруулсан байна.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг барьж байгуулах бэлтгэл ажил үндсэндээ дуусч, 1991 оны 12 дугаар сарын 23-ны өдөр анхны нүүрсээ борлуулж эхэлсэн.

1995 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус уурхайг Төрийн өмч давамгайлсан "Шивээ-Овоо" ХК болгон зохион байгуулж, компанийн дүрмийн сангийн 90% нь төрийн өмчид үлдэж, 10% нь 3300 гаруй хувьцаа эзэмшигчдэд хувьчлагдсан байна.

Нүүрсний салбарыг хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”-ний хүрээнд 1998 онд Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр уурхайн техник, технологийг шинэчлэх төсөл хэрэгжиж эхэлсэн ба 2001 оны 9 дүгээр сар гэхэд тус уурхай жилдээ 4.6 сая м3 хөрс хуулж, 2.0 сая тн нүүрс олборлох хүчин чадалтай болсон байна. Энэ төслийн хүрээнд нийт 67.6 сая ам.долларын зээлийг авч ашиглажээ.

Шивээ овоо ХК нь Шивээ-Овоогийн нүүрсний ордын 91 га талбай буюу нийт ордын талбайн 0.3 хувийг эзэмшдэг байна.

Засгийн газрын 2013 оны 100 дугаар тогтоолоор хүний хөгжил санд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг тогтворжуулах хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Шивээ овоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд уурхайн уулын ажлын /нүүрс олборлолт, борлуулалт, хөрс хуулалт/ хэмжээ тогтвортой нэмэгдэж нүүрсний дотоодын зах зээл дээр эзлэх байр суурь улам бүр бэхжиж байна.

Уулын ажил явуулж эхэлснээс хойшхи 24 жилийн хугацаанд нийт 147.8 га талбай ашиглалтанд өртөж, 155.4 га талбайд гадаад овоолго, 68 га талбайд нөхөн дүүргэлт буюу техникийн нөхөн сэргээлт, 21.6 га талбайд 82.4 сая төгрөгийн зардлаар биологийн нөхөн сэргээлтийг хийжээ.

Одоо тус компани нь ТУЗ-ийн 9 гишүүн, 3 захирал, 6 хэлтэс, 3 алба, 1 охин компани, 8 хэсгийн бүтэц зохион байгуулалттай, 547 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани 2016 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр нийт 115,179.7 сая төгрөгийн хөрөнгөтэй, үүнээс эргэлтийн бус хөрөнгө 94,359.1 сая төгрөг, эргэлтийн хөрөнгө 20,820.6 сая төгрөг, хуримтлагдсан ашгийн хэмжээ 5,021.2 сая төгрөгт хүрч, эзэмшигчдийн өмчийн дүн 6,363.1 сая төгрөг болсон байна.

Улсын төсөвт Говьсүмбэр аймгаас оруулж байгаа нийт төвлөрсөн төсвийн орлогын 83.7%, орон нутгийн төсвийн орлогын 61.0%, аймгийн нийт төсвийн орлогын 75.5%-ийг “Шивээ-Овоо” ХК дангаараа бүрдүүлж байна.

Шивээ овоо ХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим,
хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Шивээ овоо ХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 31-ыг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Шивээ овоо ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ Дөрвөн түшээ ХХК-аар боловсруулан 2010 оноос мөрдөж ажиллаж байна.

Шивээ овоо ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Шивээ овоо ХК -ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг компанийн ажилтнуудын боловсруулсан уулын ажлын мэдээ, уулын техникийн мэдээлэлтэй уялдаа бүхий “Money” программ, “Уурхайн санхүү бүртгэл” санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Шивээ овоо ХК -ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт сул байна.

Санхүүгийн дотоод хяналт нь НББ-ийг бүхэлд нь хамарч чаддаггүйгээс авлага өр төлбөр бодитой илэрхийлэгдээгүй, худалдан авалтын өртөг зөрүүтэй илэрхийлэгдсэн, хөрөнгөөр бүртгэгдэх ажил гүйлгээг зардлаар бүртгэсэн, гарсан ажил гүйлгээг бүртгээгүй орхигдуулсан зэрэг зөрчлүүд байна.

Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Шивээ овоо ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 01 дүгээр сарын 29-ны 02 тоот тогтоолоор тус компанийн 2016 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөг баталсан бөгөөд ТУЗ-ийн 2016 оны 05 дугаар сарын 18-ны 15 тоот тогтоолоор өөрчлөн баталсан байна.

2016 онд 1,950.3 мянган тонн нүүрс олборлож борлуулахаар төлөвлөсөн боловч 1,961.4 мянган тонн нүүрс олборлож, 1,880.9 мянган тонн нүүрс борлуулсан байна. Нүүрс олборлолтын төлөвлөгөө 100.6%, нүүрс борлуулалтын төлөвлөгөө 96.5%-ийн биелэлттэй байна.

Төлөвлөгөөгөөр 8,930.4 мянган метр куб хөрс хуулах байсан боловч гүйцэтгэлээр 7,214.5 мянган метр куб хөрс хуулж, хөрс хуулалтын төлөвлөгөө 80.8%-ийн биелэлттэй байна.

2016 оны бизнес төлөвлөгөөгөөр нийт 45,540.8 сая төгрөгийн борлуулалт хийж 46,700.5 сая төгрөгийн зардал гарган 1,159.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн юм.

Шивээ овоо ХК нь 2016 онд үндсэн үйл ажиллагаанаас 44,886.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 42,752.2 сая төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөөг 95.3 хувиар биелүүлсэн байна.

“ДЦС-IV” компанид нийлүүлсэн нүүрсний жилийн дундаж илчлэг 2942 ккалори/кг буюу нийлүүлэх нүүрсний стандарт илчлэг 3030 ккал/кг нийт дүнгээрээ 732.8 сая төгрөгийн олох боломжоо алдсан байна.

Хэрэглэгчдийн хувьд нийт нүүрсний 86.8 хувийг буюу 1,631.1 мянган тонн нүүрс ДЦС-4 ХК-д борлуулсан бөгөөд Бор-Өндөр УБҮ 37.6 мянган тонн, УБТЗ 39.0 мянган тонн, Дорноговийн ДС 32.7 мянган тонн тус тус худалдан авсан.

Нийт зардалд 46,700.5 сая төгрөг батлагдсанаас 43,389.3 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 3,311.0 сая төгрөгөөр хэмнэж, нийт дүнгээрээ 2,090.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

“Шилэн дансны тухай хууль”-д зааснаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу бүрэн хангаж ажиллаагүй байна. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудас shilendans.gov.mn-д ямар ч мэдээлэл оруулаагүй.
2. Өөрийн байгууллагын цахим хуудас (www.shivee-ovoo.mn) –нд удирдлагын шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар бэлтгэн интернэтэд байршуулахтай холбогдон мэргэжлийн байгууллагатай гэрээ

байгуулан ажиллаж байна. Уг цахим хуудсанд эхний 2 улирлын санхүүгийн тайлан бүртгэсэн байна.

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн шатанд нийт зардлын 1%-иар тооцож 390.0 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн шатанд өөрчлөөгүй хэвээр хадгалсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 36 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 31 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Горим сорилыг гүйцэтгэх явцад дараах тодорхойлсон үр дагаврууд гарав. Үүнд:

- Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.
- Санхүүгийн дотоод хяналт нь НББ-ийг бүхэлд нь хамарч чаддаггүйгээс авлага өр төлбөр бодитой илэрхийлэгдээгүй, худалдан авалтын өртөг зөрүүтэй илэрхийлэгдсэн, хөрөнгөөр бүртгэгдэх ажил гүйлгээг зардлаар бүртгэсэн, гарсан ажил гүйлгээг бүртгээгүй орхигдуулсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Шивээ овоо ХК -ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага өглөг, үндсэн хөрөнгө, орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртөг зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100.0 хувь, мөнгөн хөрөнгийн 85.0 хувь, нийт зардлын 80.6 хувь, эргэлтийн бус хөрөнгийн 82.0 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай холбогдох хуулийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.", 8.4. "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", 33.1. "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.", 34 дүгээр зүйлийн гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх зэрэг нөхцлүүдийг зөрчсөн, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй, 13,097.0 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллах зөвлөмж болон албан шаардлага өгөв.

2. 2016 оны 12 дугаар сарын 31 –ний байдлаар тус байгууллагын Санхүүгийн байдлын тайланд тайлагнагдсан үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 1,994.8 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө тайлагнагдсан. Мөн Сангийн Сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар дахин үнэлсэн үндсэн хөрөнгөө 2015 онд 18.9 тэрбум төгрөгийн дахин үнэлгээг буцааж, өртгийн сууриар бүртгэснээс хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг зөрүүтэй болсон. Энэ нь тохиолдсон байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: НББОУС 16 "Үндсэн хөрөнгө" -ийн "Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт" хэсэгт "Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай.", "Үндсэн хөрөнгийг дахин үнэлэх үед, тухайн хөрөнгийн харъяалагдаж байгаа үндсэн хөрөнгийн ангийг бүхэлд нь дахин үнэлэх шаардлагатай" гэснийг мөрдөх зөвлөмж өгөгдөв.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн программд ажил гүйлгээ анх оруулахдаа нотлох анхан шатны баримтыг шинжилж гүйлгээгээ хийдэггүй, ерөнхий болон нягтлан бодогч нар давхар хянаж шалгадаггүйгээс нэг харилцагчийн гүйлгээг өөр харилцагч дээр бүртгэсэн, 14.6 сая төгрөгийн НӨАТ-тай худалдан авсан бараа, ажил үйлчилгээг НӨАТ-тай дүнгээр өртөг зардалд шингээсэн, ebarimt.mn-ээр орж ирсэн НӨАТ-ын дүнгээр бодит бус өглөг үүсгэж бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг гүйцэтгэх дарааллыг баримтлаагүйгээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3 дахь заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

2. Элэгдлийн тооцооллыг давтан шалгахад 108.6 сая төгрөгийн элэгдлин зардлыг дутуу байгуулсан ба үндсэн хөрөнгө борлуулж ашиглалтаас хасахдаа 12.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг хасаагүй байгаа нь тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

3. Ажил гүйлгээг тухай бүрд нь бүртгээгүйгээс 162.2 сая төгрөгийн хөрөнгийг тайлант хугацаанд бүртгээгүй байна. Үүнд: Нисээч интернэшнл ХХК-аас санхүүгийн түрээсээр худалдан авч буй 124.5 сая төгрөгийн дугуйт ачигчийг 2016.11.08-нд хүлээн авсан бөгөөд 2017 оны 01-р сард данс бүртгэлдээ тусгасан, Тайкунминерал ХХК-аас худалдан авсан 37.7 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлдээ огт тусгаагүй байна. Мөн Монголын конвейерын тээвэр ХХК-иар шинээр хийлгүүлсэн 61.6 сая төгрөгийн /2 ш шигшүүр/ хөрөнгийг капиталжуулж бүртгэлгүй өртөг зардалд шингээсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1. дэх "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө." заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

4. Харилцагч бүрээр авлага өглөгийн тооцоо нийлэлт хангалтгүй, он дамжсан өр авлага их хэмжээтэй байна. Баталгаажуулсан зарим авлага, өр төлбөрийн үлдэгдэл болон ажил гүйлгээний тооцооллоор давтан шалгахад тайлангаарх үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Тухайлбал: Санхүүгийн тайлангаарх татварын өр авлагуудын дүн нь татварын тайлангуудаас, Эрдэнэ Эх ХХК 16.8 сая төгрөгөөр, Багануур ХК 18.8 сая төгрөгөөр, Хос үржин ХХК 3.0 сая төгрөгөөр г.м зөрүүтэй байна. Мөн ХХОАТ-ын 10.2 сая төгрөгийн авлагыг өр төлбөрийн дансанд бүртгэснээс өр төлбөр уг дүнгээр буурч тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн

тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар цэвэр дүнг гаргахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрөнгө ба өр төлбөрийн цэвэр дүнг гаргахгүй байх. Татварын байгууллагын тооцоог дахин хянаж, авлага өглөгийн дүнг бодит байдлаар илэрхийлдэг байх зөвлөмж өгөгдөв.

5. Урьдчилж гарсан зардал тооцоог хянаагүйгээс 274.4 сая төгрөгийн өмнөх үед хамаарагдах зардал үлдэгдэлтэй байна. Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

6. Гадаад валютаарх ажил гүйлгээнд ханшийн зөрүү тооцоогүйгээс гадаадын компаниудын тооцоонд 234.5 сая төгрөгийн бодит ба бодит бус ханшийн тэгшитгэл хийгдээгүй байна. /Бээжин авиак-35.0 сая, Тех индустри-175.5 сая, Транс техно-22.6 сая, Тайяань Шинхуа-1.5 сая төгрөг/ Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

7. НӨАТ-тэй худалдан авсан бараа ажил үйлчилгээний 1,178.1 сая төгрөгийн НӨАТ-ыг төлбөр төлөгдөөгүйн улмаас хойшлуулж бүртгэж байгаа нь НӨАТ-ын авлага, харилцагчид төлөх өр төлбөр дутуу илэрхийлэгдэж байгааг харуулах бөгөөд НӨАТ-ын авлагыг хянах боломжгүй болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.11. дэх “өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, ...” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

8. Гүйцэтгэх захирлын 2016 оны 04-р сарын 27-ны өдрийн А/47 тоот тушаалаар "Сэлбэг хэрэгсэл, бараа материалын захиалга гаргах, бэлтгэн нийлүүлэх, нөөц бүрдүүлэх, орлогод авах, зарлага гаргах журам"-ыг баталсан боловч огт мөрдөж ажиллаагүй байна. НББОУС-2 “Бараа материалыг анх өртгөөр нь хэмжинэ. Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг ба үйлдвэрлэлийн буюу хувиргалтын зардлыг хамруулна” заалтаар гаалиар орж ирсэн бараа материалын өртгийг тооцохдоо бодит өртгөөс илүү тооцсон байна. Тухайлбал: Бээжин

Авиакаас авсан дугуйн өртөг 80.8 сая төгрөгөөр, Тайяань Шинхуагаас авсан сэлбэгийн өртөг 5.0 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

9. Эрнст энд Янг Аудит ХХК-иар 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу удаан хугацаанд хэрэглэгдээгүй, хуучирч муудсан гэх 1,285.9 сая төгрөгийн бараа материалыг данснаас хасч, дахин ашиглаж болзошгүй гэж үзэн сөрөг утгатай сан үүсгэн хөрөнгүүдийг тусгаарласан. Тайлант хугацаанд 30.2 сая төгрөгийн тусгаарлагдсан сэлбэгийг зарлагдахдаа сэлбэг хэрэгслийн сан данстай харьцаагүйгээс хөрөнгө, зардал илүү илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4. дэх заалт “үнэн зөв байх” зарчмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Данснаас хасагдахаар тусгаарлагдсан хөрөнгүүд нь өмнөх тайлант хугацаанд зардалд бүртгэгдсэн тул зарлагдахдаа сэлбэг хэрэгслийн сан дансаар хасах зөвлөмж өгөгдөв.

10. ААНБ-аас худалдан авсан 193.2 сая төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгслийг дансандаа бүртгээгүй нь хөрөнгө болон зардал дутуу илэрхийлэгдэх, хөрөнгө шамшигдуулах эрсдэлийг агуулж байгаа ба өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сул байгааг харуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6. дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөгдөв.

11. 2012-2015 онуудад хамаарах бүртгэл тайланд татварын улсын байцаагчийн 2016.10.05-ны 360004050 тоот актаар тавигдсан 205.2 сая төгрөгийн нөхөн татвар, хүү торгууль, алдангийн төлбөрийг үндсэн үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч санхүүгийн тайлангаа залруулсан.

12. Эрдэнэс Монгол ХХК-тай үүссэн ажил гүйлгээнд холбогдох аудитын болон менежментийн зардлууд НӨАТ-тай дүнгээр илүү илэрхийлэгдсэнээр зардал өссөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4. дэх заалт “үнэн зөв байх” зарчмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

13. Тайлант хугацаанд Эрдэнэс Монгол ХХК-д төлөх лицензийн төлбөрийн 112.2 сая төгрөгийн зардал, Синус дочи ХХК-иар гүйцэтгүүлсэн 3.5 сая төгрөгийн ажил үйлчилгээг зардлаар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4. дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

14. Компани нь ажилчиддаа ажилласан жилээс хамааран тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн нөхөн төлбөр олгодог байна. НББОУС-19 Ажилчдын тэтгэвэр тэтгэмж стандартын дагуу тэтгэмжийн зардлыг ажиллах хугацаанд нь хүлээн зөвшөөрөхийг шаарддаг бөгөөд ажилчдын тэтгэврийн сангийн тооцооллыг хийхдээ 2015-2016 онуудад ажиллагсдын ажилд орсон гарсан хөдөлгөөнийг бүртгээгүйгээс 12.3 сая төгрөгийн тэтгэврийн зардал илүү илэрхийлэгдсэн байна.

Шийдвэрлэсэн: Хүлээн зөвшөөрч аудитын хугацаанд санхүүгийн тайлангаа залруулсан.

15. Тайлант хугацаанд ажиллагсдад олгосон хоолны мөнгөнөөс /211.3 сая/ ХХОАТ-ыг суутгахдаа НДШ хассан дүнгээс тооцсон байна. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 22.1.4 "Шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр", 23.1 "Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөгдөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

НББОУС 16 "Үндсэн хөрөнгө" -ийн "Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт" хэсэгт *"Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай"* бөгөөд энэ нь 2016 оны санхүүгийн байдлын тайланд тусгагдах цаг хугацааны боломжгүй нөхцөл байдлаас залруулагдаагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал нь:

1. Шивээ-Овоогийн нүүрсний орд нь нийт 29,500.0 га талбайг хамардаг бөгөөд Шивээ овоо ХК нь зөвхөн 91 га газрыг тусгай зөвшөөрлөөр эзэмшдэг байна. 2009 оноос хойш Эрдэнэс МГЛ ХХК-ийн тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас

гэрээний дагуу ашиглаж байгаа бөгөөд 2016 онд 224.4 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлж нүүрс олборлож байна.

2. Монгол улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 338 тоот тогтоолын 5-д тус компанийн НИК ХХК, Сод Монгол групп ХХК-д төлөх нийт 2.9 тэрбум төгрөгийн шатахууны өрийг Эрдэнэс Тавантолгой ХХК-ийн татварын албанд үүссэн татварын илүү төлөлтөөс суутган, дээрх нефть хангамжийн компаниудын гаалийн болон татварын илүү төлөлт болгон бүртгэх замаар шийдвэрлэхийг Сангийн сайд, Гааль татварын ерөнхий газрын дарга нарт зөвшөөрсөн ч уг тогтоол хэрэгжээгүй.
3. Шивээ овоо ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 01 дүгээр сарын 29-ны 02 тоот тогтоолоор батлагдсан 2016 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд толгой компанийн удирдлагын зардлыг нийт үйл ажиллагааны зардлын 3 хувиар тооцож оруулан баталснаар 2016 онд Эрдэнэс Монгол ХХК-д төлөхөөр 1,405.1 сая төгрөгийн менежментийн зардал бүртгэгдсэн байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Шивээ овоо ХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад бараа материалыг хариуцсан нягтлан бодогчийн ажлын хариуцлагагүйгээс гүйцээж мөшгин шалгаж амжаагүй асуудал гарсан болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Шивээ овоо ХК -ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар ТБОНӨХБАҮХА тухай хууль зөрчиж худалдан авалт хийсэн 13,097.0 сая төгрөгийн зөрчил, НББ-ийн 2,807.7 сая төгрөгийн алдаа, нийт 15,904.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс тайлант хугацааны эцэст 2,602.1 сая төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгөгдсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шивээ овоо ХК -ийн удирдлагад 2015 оны санхүүгийн тайлангийн аудитад "Есөнхангай Аудит" ХХК-аас 8 асуудлаар 14 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 5 асуудлыг шийдвэрлээгүй байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Тус компани нь бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна. Үүнд: Тус хуулийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.", 8.4. "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл

болгоно.", 33.1. "Бараа, ажил, үйлчилгээний төсөөт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.", 34 дүгээр зүйлийн гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх зэрэг нөхцлүүдийг зөрчсөн, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй, гэрээ байгуулаагүй 13,097.0 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх зөрчлийг эс тооцвол, Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан болзошгүй үр нөлөөг эс тооцвол санхүүгийн тайлангууд нь Шивээ овоо ХК -ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.


АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Я. САМБУУНЯМ

БЭЛТГЭСЭН:

ЕСӨНХАНГАЙ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР  Т.ОЮУНТУЯА

2016.03.15



ШИВЭЭ ОВОО ХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэг
харилцана уу:

Санхүүгийн Аудитын Газрын дарга,
тэргүүлэх аудитор Ц.НАРАНЧИМЭГ
Утас: 263533
Цахим хаяг:

Аудитын менежер: Я.САМБУУНЯМ
Утас: 260512

Аудитор:НЯМДАВАА

Есөнхангай Аудит ХХК
Захирал Т.ОЮУНТУЯА
Утас: 99048991
Цахим хаяг: oyuntuya@cpa.mn

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1 Санхүүгийн дотоод хяналт
Асуудал 2 Хөрөнгийн үнэ цэнэ
Асуудал 3 Худалдан авалт

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 4 Татвартай холбоотой асуудал

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Шивээ овоо ХК -ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Шивээ овоо ХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Санхүүгийн дотоод
хяналтын талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

Санхүүгийн дотоод хяналт нь НББ-ийг бүхэлд нь хамарч чаддаггүйгээс авлага өр төлбөр бодитой илэрхийлэгдээгүй, худалдан авалтын өртөг зөрүүтэй илэрхийлэгдсэн, хөрөнгөөр бүртгэгдэх ажил гүйлгээг зардлаар бүртгэсэн, гарсан ажил гүйлгээг бүртгээгүй орхигдуулсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байв.

Зөвлөмж

Хяналтууд үр нөлөөгүй байх нь хяналтгүйтэй адил бөгөөд дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг нь дээшлүүлэх арга хэмжээ авах. Санхүүгийн ажилтнуудын ажил үүргийг зохих байдлаар хуваарилах, тухайн албан тушаалаар эрх мэдэл болон гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхой болгох.

Эрсдэлүүд

Төрийн өмч бүртгэл тооцоо, хяналтаас гадуур ашиглагдан улмаар өмчид тавих хяналт сулрах.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд үнэн зөв, хүчин төгөлдөр гэдгийг нотлоход хүндрэл учрах.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудал 2: Үндсэн хөрөнгийн бодит
үнэ цэнийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

2016 оны 12 дугаар сарын 31 –ний байдлаар тус байгууллагын Санхүүгийн байдлын тайланд тайлагнагдсан үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 1,994.8 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө тайлагнагдсан. Мөн Сангийн Сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар дахин үнэлсэн үндсэн хөрөнгөө 2015 онд 18.9 тэрбум төгрөгийн дахин үнэлгээг буцааж, өртгийн сууриар бүртгэснээс хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг зөрүүтэй болсон. Энэ нь тохиолдсон байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” -ийн “Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт” хэсэгт *“Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай.”*, “Үндсэн хөрөнгийг дахин үнэлэх үед, тухайн хөрөнгийн харъяалагдаж байгаа үндсэн хөрөнгийн ангийг бүхэлд нь дахин үнэлэх шаардлагатай” гэснийг мөрдөх зөвлөмж өгөгдөв.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан, үр дүн буруу илэрхийлэгдэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Ажиглалт

Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна. Үүнд: Тус хуулийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.", 8.4. "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", 33.1. "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.", 34 дүгээр зүйлийн гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх зэрэг нөхцлүүдийг зөрчсөн, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй, 13,097.0 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21.4 "Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ." заалтыг зөрчсөн бөгөөд давхардсан тоогоор 28 тендерийн урилга тавигдаж, нэг ч тендерийн үр дүнг мэдээлээгүй байна.

□

Эрсдэлүүд

Батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлж худалдан авалт хийх нь хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, улмаар ирээдүйд ашигт нөлөөлөх

Зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудал 4: Татвартай холбоотой асуудал

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

Тайлант хугацаанд ажиглагсдад олгосон хоолны мөнгөнөөс /211.3 сая/ ХХОАТ-ыг суутгахдаа НДШ хассан дүнгээс тооцсон байна.

Санхүүгийн тайлангаарх татварын өр авлагуудын дүн нь татварын тайлангаарх үлдэгдлээс зөрүүтэй байна.

Зөвлөмж

ХХОАТ-ын тухай хуулийн 15.1.3 "Бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор", 15.1.7 "Энэ хуулийн 15.1.1–15.1.6-д заасантай адилтгах бусад орлого", 22.1.4 "Шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр", 23.1 "Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна" заалтуудыг мөрдөж ажиллах.

Татварын байгуулагын тооцоог дахин хянаж, авлага өглөгийн дүнг бодит байдлаар илэрхийлдэг байх

Эрсдэлүүд

Татварын хуулиудыг мөрдөөгүйгээс хүү торгуулийн эрсдэлд орох.

Авлага, өглөгийн бүртгэлийг тухай бүрт хийгээгүйгээс авлага болон өр төлбөр илүү эсвэл дутуу илэрхийлэгдэнэ.

Үйлчлүүлэгчийн хариу

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлангаарх үлдэгдэл		(төгрөгөөр)	
	01-р сарын 01	12 -р сарын 31	Аудитын зарруулга	Аудитлагдсан үлдэгдэл 12 -р сарын 31
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,043,196,834.20	1,626,263,897.18	-	1,626,263,897.18
Дансны авлага	3,131,702,962.85	1,627,302,144.28	30,794,812.86	1,596,507,331.42
Татвар, НДШ -ийн авлага	352,560,042.14	-	(10,225,896.43)	10,225,896.43
Бусад авлага	-	-	(1,268,236,156.64)	1,268,236,156.64
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	-
Бараа материал	10,852,537,772.57	14,105,977,094.49	99,126,646.89	14,006,850,447.60
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	1,773,345,348.18	2,586,877,940.07	274,400,870.00	2,312,477,070.07
Эргэлтийн хөрөнгийн дүн	18,153,342,959.94	19,946,421,076.02	(874,139,723.32)	20,820,560,799.34
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	57,273,813,863.71	69,499,490,235.37	(143,508,046.09)	69,642,998,281.46
Хөрс хуулалтын хөрөнгө	21,082,229,544.57	24,752,768,431.94	-	24,752,768,431.94
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-	-
Хойшлогдсон хөрс хуулалтын шавхагдал	(1,480,803,734.42)	(1,871,222,945.66)	-	(1,871,222,945.66)
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	530,131,395.36	530,131,395.36	-	530,131,395.36
Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,991,112,937.00	1,304,460,207.09	-	1,304,460,207.09
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	80,396,484,006.22	94,215,627,324.10	(143,508,046.09)	94,359,135,370.19
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	98,549,826,966.16	114,162,048,400.12	(1,017,647,769.41)	115,179,696,169.53
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	16,549,755,278.53	18,956,136,898.93	(1,418,427,586.89)	20,374,564,485.82
Цалингийн өглөг	245,259,488.15	296,388,886.57	-	296,388,886.57
Татвар, ЭМД, НДШ -ийн өр	1,449,022,186.16	1,227,076,653.58	48,888,297.64	1,178,188,355.94
Богино хугацаат зээл	2,216,666,666.50	-	-	-
Урьдчилж орсон орлого	99,331.81	-	-	-
Хүүний өглөг	425,286,231.69	317,149,520.07	-	317,149,520.07
Засгийн газрын дэмжлэг	3,111,820,512.00	3,637,483,376.00	-	3,637,483,376.00
Санхүүгийн түрээсийн өглөг	2,224,930,225.60	5,061,669,186.60	-	5,061,669,186.60
Бусад богино хугацаат өр төлбөр	23,163,246,343.74	26,526,442,965.92	-	26,526,442,965.92
Ногдол ашгийн өглөг	-	130,419,101.00	-	130,419,101.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	49,386,086,264.18	56,152,766,588.67	(1,369,539,289.26)	57,522,305,877.92
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	18,671,920,262.42	16,544,200,248.18	0.01	16,544,200,248.18
Засгийн газрын дэмжлэг	22,838,290,403.69	20,392,768,722.69	-	20,392,768,722.69
Ажилчдын тэтгэвэрийн сан	1,056,906,953.00	1,279,932,677.93	12,311,753.41	1,267,620,924.52
Санхүүгийн түрээсийн өглөг	1,560,406,840.13	10,502,656,315.95	0.01	10,502,656,315.94
Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг	-	2,104,005,152.60	(124,472,727.20)	2,228,477,879.80
Хойшлогдсон татварын өр	358,564,643.00	358,564,643.00	-	358,564,643.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	44,486,089,102.24	51,182,127,760.35	(112,160,973.76)	51,294,288,734.12
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	93,872,175,366.42	107,334,894,349.02	(1,481,700,263.02)	108,816,594,612.04
ЭЗДИЙН ӨМЧ				
Өмч : -Төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00	-	1,207,710,000.00
-Хувийн	-	-	-	-
-Хувьцаат	134,190,000.00	134,190,000.00	-	134,190,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг	3,335,751,599.74	5,485,254,051.10	464,052,493.61	5,021,201,557.49
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,677,651,599.74	6,827,154,051.10	464,052,493.61	6,363,101,557.49
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	98,549,826,966.16	114,162,048,400.12	(1,017,647,769.41)	115,179,696,169.53

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлангаарх дүн		(төгрөгөөр)	
	01-р сарын 01	12-р сарын 31	Аудитын залруулга	Аудитлагдсан дүн 12-р сарын 31
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	37,759,707,164.85	42,752,185,435.10	-	42,752,185,435.10
Борлуулалтын өртөг	32,262,231,231.00	35,289,113,128.58	111,297,625.00	35,177,815,503.58
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	5,497,475,933.85	7,463,072,306.52	(111,297,625.00)	7,574,369,931.52
Бусад орлого	4,003,239,877.00	3,145,926,388.65	-	3,145,926,388.65
	4,003,239,877.00	3,145,926,388.65	-	3,145,926,388.65
Борлуулалт маркетингийн зардал				
Ерөнхий ба удирдлагын зардал	1,663,622,008.78	2,877,088,466.03	34,334,832.86	2,842,753,633.17
Санхүүгийн зардал	164,389,100.00	-	-	-
Хүүгийн зардал	991,818,222.80	4,189,150,683.80	-	4,189,150,683.80
Бусад зардал	6,030,788,365.36	1,009,513,376.01	(170,047,138.20)	1,179,560,514.21
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/ гарз/			186,309,345.90	(186,309,345.90)
	8,850,617,696.94	8,075,752,525.84	50,597,040.56	8,397,774,177.08
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	650,098,113.91	2,533,246,169.33	(161,894,665.56)	2,322,522,143.09
Орлогын татварын зардал	65,009,811.39	253,324,616.93	(16,189,466.56)	232,252,214.31
ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)	585,088,302.52	2,279,921,552.40	(145,705,199.00)	2,090,269,928.78
Хойшлогдсон ОАТ-ын зардал				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	585,088,302.52	2,279,921,552.40	(145,705,199.00)	2,090,269,928.78
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
ОРЛОГЫН НИЙТ ДҮН	585,088,302.52	2,279,921,552.40	(145,705,199.00)	2,090,269,928.78

НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ (АЛДАГДАЛ)

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	Тайлангаарх дүн		Аудитлагдсан дүн
	2015 онд	2016 онд	2016 онд
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	41,616,764,100.00	42,300,490,611.01	42,300,490,611.01
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	40,943,880,700.00	41,439,880,308.37	41,439,880,308.37
Туслах үйл ажиллагаанаас олсон орлого	568,042,800.00	860,610,302.64	860,610,302.64
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	104,840,600.00	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	39,390,528,503.80	38,638,328,383.61	38,638,328,383.61
Ажиллагсад төлсөн	7,708,981,100.00	6,192,843,925.43	6,192,843,925.43
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,635,302,000.00	2,074,942,452.00	2,074,942,452.00
Бараа материал худалдан авахад төлсөн	16,562,932,300.00	17,613,866,437.56	17,613,866,437.56
Ашиглалтын зардалд төлсөн	8,566,264,900.00	6,602,597,647.06	6,602,597,647.06
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	339,328,938.00	-	-
ТУЗ, томилолт бусад зардал	-	261,149,742.10	261,149,742.10
Хүүний төлбөрт төлсөн	392,230,400.00	533,295,741.59	533,295,741.59
Татварын байгууллагад төлсөн	3,183,172,000.00	4,359,190,782.21	4,359,190,782.21
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	57,765,116.21	57,765,116.21
Бусад мөнгөн зарлага	1,002,316,865.80	942,676,539.45	942,676,539.45
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,226,235,596.20	3,662,162,227.40	3,662,162,227.40
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	1,152,200.00	438,525,227.00	438,525,227.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,152,200.00	438,525,227.00	438,525,227.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,722,246,000.00	3,235,000,000.00	3,235,000,000.00
Үндсэн хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн	1,572,246,000.00	3,235,000,000.00	3,235,000,000.00
Хөрөнгө оруулалт олж, эзэмшихэд төлсөн	150,000,000.00	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,721,093,800.00)	(2,796,474,773.00)	(2,796,474,773.00)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	5,459,542,200.00	5,617,110,075.75	5,617,110,075.75
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,454,000,000.00	5,612,458,381.46	5,612,458,381.46
Төрөл бүрийн хандив	5,300,000.00	-	-
Валютын ханшийн зөрүү	242,200.00	4,651,694.29	4,651,694.29
Мөнгөн зарлагын дүн (-)	5,042,902,800.00	6,899,730,467.17	6,899,730,467.17
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,229,811,600.00	6,488,110,933.78	6,488,110,933.78
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	2,807,780,000.00	55,200,000.00	55,200,000.00
Төрөл бүрийн хандив	-	28,305,788.00	28,305,788.00
Хүүгийн зардалд	-	328,113,745.39	328,113,745.39
Валютын ханшийн зөрүү	5,311,200.00	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	416,639,400.00	(1,282,620,391.42)	(1,282,620,391.42)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	921,781,196.20	(416,932,937.02)	(416,932,937.02)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,121,415,638.00	2,043,196,834.20	2,043,196,834.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,043,196,834.20	1,626,263,897.18	1,626,263,897.18

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 01 -р сарын 01 -ий үлдэгдэл	1,341,900,000.00	20,329,391,486.41	11,964,340,100.26	9,706,951,386.15
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(20,329,391,486.41)	14,715,003,397.07	(5,614,388,089.34)
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	0.00	2,750,663,296.81	4,092,563,296.81
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			585,088,302.52	585,088,302.52
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2015 оны 12 -р сарын 31 -ий үлдэгдэл	1,341,900,000.00		3,335,751,599.74	4,677,651,599.74
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(274,400,870.01)	(274,400,870.01)
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00		3,061,350,729.73	4,403,250,729.73
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			2,090,269,928.78	2,090,269,928.78
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг			(130,419,101.02)	(130,419,101.02)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2016 оны 12 -р сарын 31 -ий үлдэгдэл	1,341,900,000.00		5,021,201,557.49	6,363,101,557.49